



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/184

Баян-Өндөр сум

“Эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны  
арга хэмжээний төлөвлөгөө, төсвийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.3, 11.1.7, 11.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Ээлжит XIII хуралдааны 13/09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны арга хэмжээний төлөвлөгөө, төсвийг хавсралтаар баталсугай.

2.Зардалд шаардагдах 150,000,000 (Нэг зуун тавин сая) төгрөгийг Төсөл хөтөлбөрийн зардлын Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг дэмжих “Эмч” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зардлаас гаргаж, батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Бямбацэцэг)-т зөвшөөрсүгэй.

3.Батлагдсан төсвийг үр дүнтэй зарцуулж, тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Сүхээ)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (А.Бумансор)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2023 оны  
03 дугаа сарын 24-н өдрийн  
11/24 дугаар захирамжийн завсралт

**“ЭМЧ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2023 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Санхүүжилтийн эх үүсвэр
1	Эмч эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад хамруулах. Үүнд: -Уламжлалт анагаах ухааны эмч, мэргэжилтнийг чадавхжуулах -Эх ураг судлал -ӨЭМТ-ийн эмч нарыг нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багцын чиглэлээр чадавхжуулах, зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээ -ХАБЭА-н ажилтан бэлтгэх сургалт -Хэт авиан оношилгооны мэргэжил олгох сургалт -Яаралтай тусламжийн сувилагч бэлтгэх -Харшил судлалын сургалт	Төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	75%	78%	ЭМГ	ЗДТГ, эрүүл мэндийн байгууллагууд	18,416.000 сая төгрөг орон нутгийн төсөв
2	Орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэшүүлэх сургалтад хамрагдахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх. Үүнд: -Улаан хоолойн ЭХО -Тархины цахилгаан бичлэг -Хүүхдийн нүдний мэс заслын чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах	Нэн шаардлагатай мэргэжил эзэмшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	60%	65%	ЭМГ	ЗДТГ, эрүүл мэндийн байгууллагууд	6,000.000
3	Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд эрдэм шинжилгээний хурал, судалгааны арга зүй сургалтыг зохион байгуулах	Судалгаа шинжилгээ хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	18%	19%	ЭМГ	ЗДТГ, эрүүл мэндийн байгууллагууд	5,000.000
4	Мэргэжлийн зэрэг ахиулахад дэмжлэг үзүүлэх	Мэргэжлийн зэрэгтэй эмчийн эзлэх хувь	24%	25%	ЭМБ-ууд	Эрүүл мэндийн байгууллагууд	Тухайн байгууллагын төсөв

5	Өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Үүнд: -Вьетнам улс -БНСУ -Малайз улс -Тайланд улс	Боловсролын зэрэгтэй эмчийн эзлэх хувь	12%	12,5%	ЭМГ, ЭМБ-ууд	ЗДТГ, гадаад, дотоодын их дээд сургуулиуд	22,750.000
6	Эрүүл мэндийн салбарын ажилтнуудад дэмжлэг үзүүлэх зөвлөл	Хамрагдсан эмч мэргэжилтний тоо	20	20	ЭМГ, ЗДТГ	Эрүүл мэндийн байгууллагууд	25,000.000
7	ӨЭМТ-ийн лаборант, техникчийг чадавхжуулах сургалт	Суралцсан эрүүл мэндийн ажилтны тоо	10	10	ЭМГ	ЗДТГ Эрүүл мэндийн байгууллагууд	4,334.000
8	Гадаад, дотоодын эмч нартай ажил мэргэжлийн туршлага солилцох буюу БНСУ-ын Дэгү хотын эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах, туршлага солилцох	Сэлгэн ажилласан эмчийн тоо	3	3	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд, хандивлагч орнууд	25,000.000
9	Эрүүл мэндийн "Анагаах увидас" сэтгүүлийг хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Хэвлүүлсэн сэтгүүлийн тоо	200	200	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд	6,500.000
10	Нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах. Үүнд: -Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн -Дэлхийн эмч нарын баярын хурал -Олон улсын сувиллагчдын өдрийн баярын хурал -Дүрс оношилгооны эмч нарын чуулга уулзалт	Уулзалт зөвлөгөөний тоо	1	1	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд	14,000.000
11	Эрүүл мэндийн ажилтны ёс зүйг хуавь хүний хандлагад тулгуурлан төлөвшүүлэх сургалтыг зохион байгуулах	Ёс зүйн зөрчил гараагүй байх	-	-	Эмнэлгийн мэргэжилтни ёс зүйн хороо	ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд	1,000.000
12	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, байгууллагын хөгжил, удирдлага төлөвлөлт, зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор 4	Сэтгэл ханамжийн судалгаа хийсэн тоо	85%-иас дээш	-	Залуу эмч нарын холбоо ТББ	ЗДТГ	



	ӨЗМТ-үүд мэргэжилтэн ханамжийн судалгааг авах	үйлчлүүлэгчид эмнэлгийн ажилтнуудын сэтгэл судалгааг авах	Эрүүл мэндийн байгууллагуудын байгууллагуудын сургалтад хамрагдсан байгууллагуудын тоо	4	4	Төрийн бус байгууллага	Тухайн байгууллагын төсөв
13	Эрүүл мэндийн байгууллагуудын менежментийг сайжруулах чиглэлээр олон улсын чанарын тогтолцооны сургалтыг зохион байгуулах	Сургалтад хамрагдсан байгууллагуудын тоо	80%-иас дээш	4	ЭМГ	Төрийн бус байгууллага	2,000,000
14	Эрүүл мэндийн ажилтнуудыг бамбайн булчирхайн дааврын шинжилгээнд хамруулах	Шинжилгээнд хамрагдсан ажилчдын тоо	80%-иас дээш	1	ЭМБ-ууд	Аймгийн ЭМБ-уудын ҮЭХ	16,000,000
15	Эрүүл мэндийн ажилчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх чийрэгжүүлэлт болон амрах өрөөг засаж тохижуулах, аймгийн эрүүл мэндийн салбарын баг тамирчдыг УБ хотын спортын наадамд оролцоход дэмжлэг үзүүлэх	Тохижуулсан танхимын тоо	1	1	ЭМБ-ууд	ЭМГ, ЗДТГ, хандивлагч байгууллагууд	4,000,000
16	Эрүүл мэндийн байгууллагуудын ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, цаг үеийн мэдээллээр хангах	Сургалт мэдээлэлд хамрагдсан хувь	15%	20%	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Төрийн болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд
17	Аймгийн "Тэргүүний эрүүл мэндийн ажилтан" сонгон шалгаруулж урамшуулах	Шалгарсан эрүүл мэндийн ажилтны тоо	1	1	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Орон нутгийн төсөв
Нийт төсөв							150,000,000